

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 7 дугаар сарын 16-ны өдөр

№ 20

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 08 цаг 00 минутад аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболдын албан өрөөнд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд удирдаж, хуралд нийт 18 удирдах албан тушаалтнууд оролцохоос 9 оролцож хуралдааны ирц 50 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Хэлтэс, алба, сумдын дарга нарын өнгөрсөн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох шуурхай мэдээ, мэдээллийг танилцуулах, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

Хуралд оролцсон хэлтэс, албад, сумдын дарга нар өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлын тайланг танилцуулав.

ҮҮРЭГ, ДААЛГАВАР:

П.Баярсайхан: Энэ жил Архивын улсын үзлэг ирэхтэй холбогдуулан аймгийн үзлэгийн комисс ажиллаж байгаа. Нэлээдгүй зөрчлүүд илэрсэн. Үүнийг залруулах арга хэмжээг хугацаанд нь авах шаардлагатай байна.

Маргааш аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралтай. Манайхаас 3 асуудал орж байгаа. Дахин төлөвлөлт, паркийн өмчлөлийн асуудал, ерөнхий төлөвлөгөө гэсэн 3 асуудал орно. 22-ны өдөр Төлөөлөгчдийн хуралдаантай. Ерөнхий төлөвлөгөө, бичил уурхайн 2 асуудал орно. Хариуцсан хэлтсийн дарга нар, мэргэжилтнүүд сайтар нягталж оруулах шаардлагатай байна.

Энэ 7 хоногт багийн төвийн нээлт байгаа гэж Дархан сумаас мэдээлэл хийлээ. Тодорхой цаг, мэдээллийг манай хэлтэст ирүүлнэ үү. Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж оруулна.

Т.Ганболд: Ихэнх дарга нар ээлжийн амралтаа авсан байна. Орлож байгаа хүмүүсийг тодорхой болгох. /ТЗУХ/

Маргааш Тэргүүлэгчдийн хуралтай тул бэлтгэлийг хангах. /ТЗУХ/

Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гарсан байх ёстой. Яамнаас албан даалгавар ирсэн үү? Тодруулаарай. /ЗА/

Замын компани өнөөдөр ирэх байх. Хустай хүртэл 1000 гаран мал тоолсон. Энийг яах вэ? /ЗА/

Зарлаагүй тендерийн талаар мэдээллийг надад өгөөрэй. Маргааш Хөрөнгө оруулалтын ажлуудтай Батсүх, Батсайхантай явж би үзнэ. /ХОХБТХ/

Постоо буулгая. Яамтай ярьж постоо буулгах талаар яриарай. Шороон замаар явж явж очдог. Мөнгө нэхдэг. Ард иргэд маш их бухимдаж байна. Яамтай нь яриад постыг нь буулгуулах шаардлагатай байна.

Энэ 7 хоногт багтааж Шунхлайгийн колонкийг буулгая. Ус сувгийн шугам байгаа. /ЗА/

16 дугаар сургуулийн талбайн зураг төсвийг Дархан сум хийсэн байна. Дархан сум зургаа Батсүх даргад өгөөрэй. Батсүх үзээд танилцуул /Дархан сум, ХОХБТХ/

Жижиг дундын захирамж гарсан байх ёстой. Банкинд очоогүй байна. Яаралтай хүргүүлэх шаардлагатай байна. /СТСХ, ХОХБТХ/

Архивын үзлэг удахгүй эхэллээ. Алтанчимэг дарга амарсан. Архивын дарга нь амарсан. Анхаараарай. Хууль зүйн сайдад хүсэлт тавьж байгаад хойшлуулсан. Алтанчимэгийг орлож байгаа хүн нь хэн юм? Энхсайхан хаана байгаа юм? Энэ асуудлыг эзэнжүүлээрэй. Амарч орч ирээд л улсын үзлэг шүү. /ХЭЗХ/

Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ-д хяналтын хороо явж ажилласан. Аймгаас ажлын хэсэг гараад очиж ажилласан. Тэр протоколыг нь олж үзмээр байна. Үргэлжлүүлэх юм уу? Яах юм? /ХОХБТХ/

Дахин төлөвлөлтийн шинэ байрны ус юу болсон бэ? Өртэй айлуудын усыг хаасан байсан. Наадмаар юу болсон бол? /ЗА/

“Шарилжгүй Дархан” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багийн оролцоо муу байна. Багууд нутаг дэвсгэр дээрээ байгаа аж ахуйн нэгжүүдээ үүрэгжүүлээд биелэлтийг нь тооцоод аваарай. /Дархан сум/

Мэдээ тайлангууд цагтаа явж байгаа юу /ТЗУХ, ХШҮДАХ/

Нийгмийн хөгжлийн төлөвлөгөөний сургалтын талаар мэдээлэл хэрэгтэй байна. 17,18-ны өдрүүдэд манайх болон Дархан сумын хурлын зааланд хийнэ гээд МТА-д би хэлж бичүүлсэн байх ёстой. 50 хүний сургалт төслөөс зохион байгуулах юм билээ. 98112460 утсаар холбогдоод надад мэдээлэл өгөөрэй. /ХОХБТХ, МТА, Дархан сум/

Наадмын тайланг түргэн авах. Өнгөрсөн жил асуудал үүссэн шүү. Явсаар байгаад намар болоод өр нь нэхэгдээд колонкууд нь шатахуун өгөөгүй. Худалдаа, үйлчилгээний ажлын хэсэг 3 сая төгрөг орлого тасалдуулсан. Одоо комиссуудаас нь тайлангаа аваарай. Энэ жил бас л орлого тасалдсан гэсэн юм яриад байна лээ шүү. Станцын Чимэддорж захирлаас мөнгө гаргуулаад морины шагнал өгсөн байгаа. Эртхэн тайлангаа гаргаад хүмүүст мөнгийг нь буцааж олгоорой. /СТСХ/

Маргааш 14.00 цагаас цахим хуралтай. Оролцоог хангуулах. /ТЗУХ/

ХЭЗХ-ийн ахлах мэргэжилтэн Г.Энхсайханыг миний өрөөнд дуудаарай. /ТЗУХ/

Хурал 09 цаг 05 минутад дуусав.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС